


Хаврын улиралд цаг агаар тогтворгүй байдагтай холбоотой агаарын температурын хэлбэлзэл ихэсдэг. Манай орны 4 дүгээр сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон томоохон гол, нуурын сав газраар 0°C (32°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар +6°C (42.8°F) –аас +12°C (53.6°F), бусад нутгаар 0°C –аас +5°C (32°F –аас 41°F) хүйтэн байдаг байна.


Монгол орны хэмжээнд 4 дүгээр сард хур тунадас бага унадаг ба ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 3 хувьтай тэнцдэг. Тус сард Булган, Хөвсгөлийн зүүн хойд хэсгээр 10-17 мм, Ховд, Говь-Алтай болон нутгийн өмнөд хэсгээр 0.2-4.9 мм бусад нутгаар 5.0-10 мм тунадас ордог байна.



**Зураг 1.** 1991-2020 оны 4 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны газарзүйн тархалт


2022 оны 4 дүгээр сарын агаарын дундаж температур өмнөх жилээс 0.4°C-аар, ОЖД-аас 1.2°C-аар дулаан байсан бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 22 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын дундаж агаарын температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нутгийн 57.4% нь ОЖД-аас +1.0–ээс +7.3°C-аар дулаан, 42.6% нь ОЖД-ийн орчим байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 5.7 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 90%-иар, ОЖД-аас 10.8%-иар бага бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 31 дахь бага тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 32.6% нь дунджаас ахиу, 59.7% нь дунджаас бага, 7.8% -д ОЖД-ийн орчим хур тунадас унасан байна.




**Зураг 2.** 2022 оны 4 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын газарзүйн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 4 дүгээр сарын хоногийн дундаж агаарын температурын явцыг авч үзэхэд (Зураг 3) 1 дүгээр 10 хоног, 2 дугаар 10 хоногийн сүүл, 3 дугаар 10 хоногийн эхээр нийт нутгаар ОЖД-аас +0.4-өөс +11.0°C дулаан байсан. Харин 2 дугаар 10 хоногийн эхээс дунд хүртэл, 3 дугаар 10 хоногийн дундаас сарын сүүл хүртэл бүх нутгаар -0.3-аас -7.1°C хүйтрэлт ажиглагдсан байна. Хур тунадасны хувьд 2, 3 дугаар 10 хоногт баруун, төв, өмнө нутгаар, 3 дугаар 10 хоногт зүүн нутгаар харьцангуй их хур тунадас ахиу оржээ.



**Зураг 3.** Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Тус сард агаарын температурын үнэмлэхүй их утга Баянхонгорын Эхийнголд 28.7°C, үнэмлэхүй бага утга Завханы Тосонцэнгэлд -19.2°C хүрчээ. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Ховдын Байтаг, Зэрэг, Баянхонгорын Эхийнголд 51°C, үнэмлэхүй бага утга Улаанбаатарын Тэрэлжид -24°C хүрч хүйтэрсэн. Хоногт хамгийн ихдээ Баянхонгорын Жинстэд 16-ны өдөр 19.6 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 961.3гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 758.4гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Төв аймгийн Баянчандманд 40 м/с хүрчээ.



**Зураг 4.** Тус сард ажиглагдсан экстремаль утгууд